

хийж гүйцэтгэх, дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах алба хаагчдын аюулгүй байдлыг ханган ажиллах талаар зөвлөмж боловсруулан мөрдүүлэх. тухайн төрлийн хэрэг шалгах ажиллагаанд шаардлагатай олон улсын хэмжээнд ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүр хангах зэрэг саналыг дэвшүүлж байна.

*Н.Амарсанаа -Хууль сахиулахын удирдлагын академийн
821 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн хошууч*

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТАНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Хураангуй. Энэхүү сэдвээр цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байгаа талаар таамаглал дэвшүүлэн гаргахыг зорилоо.

Түлхүүр үг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүй, ажлын дүн мэдээний үзүүлэлт, төрөлс баримтлах бодлого.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь эдийн засаг, соёл, ёс суртахуун, тухайн нийгмийн төлхөн тодорхой нөхцөл, хөмрөлийн аж амьдралын төвшин, хуулийн хэрэгжилт. эрх зүйн соёл, улс төрийн удирдлагын чадвар зэрэг олон талын хамааралтай байдаг.

Гэмт хэрэгтэн төрийн оршин суугаа гудамж, хорооны нутаг дэвсгэртээ гэмт хэрэг үйлддэг, төрөл хэлбэл ахуйн хүрээнд үйлдэгддэг байсан бол одоо цагт илүү зохион байгуулалттай, бэлэглэж, нууц далд аргаар төргөн хүрээнд гарах боллоо.

Гэмт хэрэг үйлдэж буй арга, ашиглаж байгаа техник хэрэгсэл орчин үеийн хөгжил, глобалчлалыг дагаад улам боловсронгуй болж төрчлөгдөж байгаагийн эсрэг цагдаагийн байгууллагын алба хаагч бид ажилдаа мэргэшсэн байхаас гадна цаг өтөйгээ хүл нийлүүлэн алхах чадвартай байх хэрэгцээ тулгарч байна.

Хууль сахиулах байгууллагаас гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэний дараа төлнийг илрүүлэхээр ажиллахад ихээхэн цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө зарцуулагдахаас гадна нийгэм, эдийн засагт тэр хэмжээгээр хохирол учирч, хууль тогтоомж зөрчигддэг.

Иймд гэмт хэргийг гарсны дараа биш гарахаас өмнө урьдчилан сэргийлэх нь нийгмээрээ амар тайван, аюулгүй ажиллаж, амьдрах нөхцөл боломжоор хангагдах зүй тогтолтой юм.

Манай улсын нийгмийн амьдралд бодитойгоор тулгамдаж буй, шийдвэрлэхэд тивэгтэй нэг асуудал нь гэмт хэрэг юм. Үүнд гэмт хэргийн төвшин, тогтоц, гарал үүсэл зэрэг асуудлууд багтаж байгаа бөгөөд үүнийг олон нийтийн мэдээллийн хэрэгслэл болон Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвөөс иргэдэд хүрч байгаа мэдээлэл зэрэг эх сурвалжууд нотолж байна¹.

Улсын хэмжээний эрүүгийн нөхцөл байдлыг дүгнэвэл 14,1 гэмт хэрэг тутамд нэг хүн нас барж, 2,6 гэмт хэрэг тутамд нэг хүн гэмтжээ.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг зохион байгуулах, дээрх ажил арга хэмжээнд иргэд, олон нийт, засаг захиргааны нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулах гол эрх зүйн зохицуулалт нь “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хууль юм.

Уг хууль Улсын Их Хурлаас 1997 оны 12 дугаар сарын 05-ны өдөр батлагдаж, үндсэндийг хүртэл хэрэгжиж байгаа бөгөөд уг хууль хэрэгжиж эхэлснээс хойш багагүй хугацаа өнгөрч, нийгмийн хэрэгцээ шаардлагаар хуулийн хэрэгжилттэй холбоотой урьдчилан сэргийлэх бодлогын шинжтэй зарчмын өөрчлөлтийг хийх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Төр засгаас хуулийг шинэчлэн найруулах талаар удаа дараагийн санал гарч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн захирамж², Хууль зүйн сайдын тушаалын³ дагуу ажлын хэсэг байгуулан ажиллаж байсан боловч тодорхой бус шалтгааны улмаас саатаж, хэрэгжилгүй иржээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам нь эрх зүй, зохион байгуулалтын хувьд тэр бүр боловсронгуй биш байгаа нь дээрх захирамж, тушаалаас харагдаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг нийгмээрээ зөвхөн цагдаагийн байгууллага хариуцан хэрэгжүүлэх ёстой гэсэн үзэл баримтлалыг өргөй болгох нь хамгийн чухал юм.

Ингэж ойлгох нь ч одоогийн үйлчилж байгаа хуулийн зарим зүйл заалтаас харгадгаж байна. Тухайлбал:

¹ Нийслэлийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйн зөвлөмж. - УБ., 2012.

² Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 29 дүгээр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсэг байгуулах тухай” захирамж.

³ Хууль зүйн сайдын 2013 оны А/210 дугаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсэг байгуулах тухай” тушаал.

а. Хяналт шалгалтын болон хууль сахиулах тусгай зорилготой байгууллагууд /МХБ, ХХБ, ГЕГ, ОБЕГ, ТЕГ, АТГ, ШШГБ/, тэдний чиг үүргийг бэрхшээл тусгаарлах.

б. Уг хуульд хорих ял эдлээд суллагдсан болон хорихоос эрх зүйн ялтай этгээдэд цагдаагийн байгууллага захиргааны хяналт тогтоох эрх зүйн зохицуулалтыг тусгаж үзүүлнэ. Цагдаагийн албаны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд тусгагдах ёстой гэж үзэж байна.

в. Мөн энэ хуулиар иргэнд “архидан согтуурч нийгмийн хэв журам зөрчиж байгаа этгээдийг амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулахгүйгээр эрүүлжүүлэх” үүргийг хийлгээдэг. Иймд хуульчид тусгай зорилготой байгаа хуульд дүн шинжилгээ хийж, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуультай уялдуулан шинэчлэх тодорхой санал дэвшүүлэн гаргах нь зүйтэй юм. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 15 дугаар зүйл 8 “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 10 дугаар зүйл Хамгийн наад зах нь “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” гэснийг “Гэмт хэрэг, зөрчлөх урьдчилан сэргийлэх тухай” гэж нэрнээс нь эхлэн зөрчлөх шаардлагатай гэж үзэж байна.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тусгай зорилготой “ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээ” гэж заасныг “нөхцөлийн шинжтэй, хязгаарлалтын шинжтэй, хяналтын шинжтэй, олон талт, хамтарсан, тодорхой тусгай арга хэмжээ” гэх мэтчилэн дээрх хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай байна. Энэ нь цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын зорилготой сайжруулах, тухайн ажилд оролцох тусгай болон тусгай бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Мөн нээс гадна 1997 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах нь цагдаагийн байгууллагын хуулиар хийгдсэн чиг үүргийн нэг юм.

Цагдаагийн байгууллагаас зохион байгуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах дараах ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож, хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Тэргүүлэх чиглэл болгохын тулд Засгийн газар, Улсын Их Хурал, Хууль зүй дотоод хэргийн яамнаас бодлогын арга хэмжээ авч, Цагдаагийн байгууллагын стратеги тусгай зорилготой боловсруулах, уг

төлвлөгчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг тусган тухайн ажилд зарцуулагдах төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд урьдчилан сэргийлэх ажлын төрлийг "ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээ"¹ гэж заасан ба хэв журмын алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулсан тоон үзүүлэлтээр онооны системд оруулан дүгнэж ирсэн нь алба хаагчдаас хуулийн хэрэгжилтэд бодитой бус хандах, онооны хойноос хэт хяналт хасуудлуудыг үүсгэсээр ирсэн.

Судалгааны явцад нийслэлийн дүүргийн дугаар хорооны нутаг дэвсгэрт ийл ажиллагаа явуулдаг хянганы дэлгүүрийн эзэн "Б"-тэй хийсэн ярилцлаганд "Манай хорооны хэсгийн байцаагч нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сард нэг удаа албан мэдэгдэл өгч, хариу авдаг ба тэр албан мэдэгдлийн өг, өгөхлөр нь бүгд адилхан байдаг. Түүний дагуу ажил зохион байгуулаад хариу өг гэдэг. Би мөн анх өгсөн мэдэгдлийн хариугаа сар, өдрийг нь засаад л өгдөг..." гэж дурьдсан.

Дээрх ийл ажиллагаа улсын хэмжээнд ажиллаж байгаа цагдаагийн хэсгийн байцаагч нар дээр давтагдаж байх магадлалтай юм.

Иймд цагдаагийн байгууллагаас зохион байгуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг өнөлж, дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох шаардлагатай юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь маш өргөн ойлголт бүгүүд өөрөөр хэлбэл нийгмийн бүх сөрөг үзэгдэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх гэсэн ойлголт гэж үзэж байна.

Иймд дээрх асуудлыг дан ганц цагдаагийн байгууллага хэрэгжүүлэх боломжгүй бүгүүд гагцхүү цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гүйцэтгэх ажлын хүрээ, хязгаарыг эрх, өргийнх нь хүрээнд тогтоож, хэрэгжүүлэх нь чухал гэсэн таамаглалыг дэвшүүлж байна.

1. 1997 онд батлагдсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль хорин жилийн хугацаанд түүхэн өөргөө гүйцэтгэсэн бүгүүд. Өнөөдрийн нийгмийн хөгжил, эрх зүйн зохицуулалтын орчинг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төрөл, хэлбэрийг өргөжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд төр, олон нийт, иргэдийн оролцоо, хүрээг өргөтгөх, тэдний өөрөг, хариуцлагыг дээшлүүлэх талаасаа шинээр боловсруулах хэрэгцээ, шаардлага зүй ёсоор бий болсонд дүгнэлт

¹ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйл.